

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА.
ЗАСАГ ДАРГА НАРЫН НЭГДСЭН УУЛЗАЛТ, СЕМИНАРЫН МӨРӨӨР АВАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2021.06.16

Цагаандэлгэр

№	Асуудал, арга хэмжээ	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хэрэгжилт	Хувь
1	"Цахим үндэстэн" болох, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр ажиллах	Сумдын ЗДТГ Г.Эрдэнэтуяа	Е-Mongoli системээр төрийн 50 орчим байгууллагын 516 үйлчилгээг үзүүлэх боломжтой болсон. Е-mongolia системээс 19 иргэнд 22 төрлийн лавлагаа гаргаж үйлчилсэн байна.	100
2	Дундаж орлоготой өрхийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	Сумын ЗДТГ О.Нандин-Эрдэнэ	Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан ажиллаж сумын хэмжээнд байгаа дундаж орлоготой 15 өрхөөс өрхийн үнэлгээний хуудсаар судалгаа авч тухайн өрхийн хөгжлийн явцыг тодорхойлон ажиллаж байна.	50
3	Сумын хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах	Сумдын ЗДТГ Б.Цэндмаа	СХС-ийн зээлдэгчдийн мэдээлэлтэй, гэрээтэй танилцаж хугацаа хэтэрсэн зээлдэгчидтэй биечлэн болон, утсаар, цахимаар холбогдон зээлийн мэдээллийг танилцуулж 2 өрхийн зээлийг бүрэн хаалгасан. СХС-ийн хяналтын зөвлөлийг 1 удаа хуралдуулсан. Нийт 27 зээлдэгч байгаагаас 2 зээлийг бүрэн хаасан, 3 зээлдэгч хугацаандаа төлж байгаа. Шүүхээр шийдвэрлэгдсэн 7 зээлдэгч байгаа боловч төлөлт хийгдээгүй. 15 зээлдэгч хугацаа хэтрэлттэй байгаа. Тэдгээр зээлдэгчтэй нэг бүрчлэн утсаар болон цахимаар хобогдсон. Цаашид хугацаа хэтрэлтийг багасгах талаар ажиллаж байна.	50
4	Төрийн захиргааны албан хаагчдын хууль бус халгаа сэлгээг зогсоох, холбогдох хуулийг хэрэгжүүлж ажиллах	Сумдын ЗДТГ З.Солонго	ЗДТГ-т төрийн захиргааны 7 албан хаагч ажиллаж байна. Үүнээс 2 албан хаагч төрийн албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн байна. Төрийн захиргааны албан хаагчдыг хууль бусаар халсан зүйлгүй.	100

5	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн дагуу судалгааг нарийвлан гаргах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах		Сумын төрийн албан хаагчдын нэгдсэн судалгааг гаргасан. ЗДТГ-ын төрийн үйлчилгээний 5 албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж дүгнэн 2518795 төгрөгийн ур чадварын нэмэгдлийг олгосон. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 2 албан хаагчид, ар гэрийн гачигдал гарсан 1 хаагчид, өөр ажилд шилжиж ажиллахаар болсон 2 албан хаагчид байгууллагын дотоод журмын дагуу мөнгөн дэмжлэг үзүүлсэн. Дэлхийн зөн ОУБ-аас өрх толгойлсон 1 төрийн үйлчилгээний албан хаагчид гэр олгуулах ажлыг зохион байгуулсан. ЭМТ-ийн албан хаагчдаас 2 удаа ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааг авч нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт төлөвлөгөө боловсруулан тусгасан. Ажилчдын амралтын өрөөг тохижуулан зурагт, ус буцалгагчийг шинээр нэмж тавьсан. Сувилагч нарт амин үзүүлэлт хянах даралт хэмжигч, чагнуур, пульсоксиметр, амьсгал тоологч, халууны шилийг шинэчилж өгсөн. Хүүхдийн цэцэрлэгээс албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 11 ажилчдад үр дүнгийн урамшуулалыг 2 удаа олгож, 4282171 төгрөг, ур чадварын нэмэгдлийг 3 удаа олгож, 3650002 төгрөг, тогооч А.Бямбасүрэнд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахад цалинтай 14 хоногийн чөлөө олгож, 337848 төгрөг, албан хаагчдыг эрүүл мэндийн шинжилгээг өгөхөөр явахад 90000 төгрөг, дотоод журмын дагуу 175590 төгрөгийн цалинтай чөлөөг 4 албан хаагчид тус тус олгож ажилласан.	100
6	Төрийн албан хэрэг хөтлөлтийн байдалд үзлэг хийж, стандартыг чандлан мөрдөх, архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжлийн болон энэ чиглэлээр мэргэшсэн бичээч, бичиг хэргийн ажилтныг томилон ажиллуулах	Сумын ЗДТГ Г.Эрдэнэтуяа	ЗДТГ-ын архив, бичиг хэргийн эрхлэгч 2005 оноос хойш тогтвор суурьшилтай ажиллаж байна. Мэргэжлийн архивч үнэмлэхийг 2013 онд авсан. Архивын ерөний газрын мэргэжил дээшлүүлэх сургалтад 4 удаа хамрагдсан.	100
7	Албан тушаалтнуудын сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчдад хариуцлага тооцох чиглэлээр арга хэмжээ авах	Байгууллагын удирдлагууд	ЗДТГ-аас 17 төрийн албан хаагчидтай 2021.01.14-нд ёс зүй, хариуцлагын гэрээ байгуулсан. 1 албан хаагчид цалингийн хувь бууруулах, 1 албан хаагчид ажлаас халах сахилгын шийтгэл оногдуулсан. ЕБС-аас багш, ажилчидтай 2021.01.05-нд ёс зүйн гэрээг байгуулан сахилга, ёс зүйн доголдол, зөрчилгүй ажиллаж байна. НТБ-ын үндэсний төвөөс зохион байгуулсан “Ёс зүйн боловсрол” олгох 3 хоногийн цахим сургалтанд НТБ-ын багш Н.Оюунцэцэг хамрагдан сургуулийн нийт 22 багш, ажилтанд “Ёс	70

			зүйн хариуцлага” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. ЭМТ-ийн 15 албан хаагчдад эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ сэдвээр 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Соёлын төвөөс 6 албан хаагчидтай ёс зүйн гэрээг байгуулж зөрчил дутагдалгүй ажиллаж байна.	
8	Төсөвт тусгагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны ажлыг яаралтай зохион байгуулах, зарлагдаж буй тендерийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, концессын хэрэгжилтэд анхаарал хандуулах	Сумын ЗДТГ Н.Батгэрэл	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг эрэмбэлэх ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсэг хуралдаж батлагдсан ажлуудыг эрэмбэлсний дагуу эхний 3 ажил санхүүжилтийн дагуу гэрээ байгуулах шатандаа явагдаж байна. Дараагийн ажлуудыг санхүүжилт орж ирсэн тухай бүрт зохион байгуулан ажиллахаар төлөвлөсөн байна.	50
9	Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийж эрчимжүүлэх арга хэмжээ авах	Сумын ЗДТГ З.Солонго	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийг дүгнэн гаргахад хагас жилийн байдлаар 50%-тай хэрэгжиж байна. Нийт 16 заалт байгаагаас цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай 6 арга хэмжээг байгааг тооцож холбогдох албан хаагчдад ажил эрчимжүүлэх үүрэг чиглэл өгч ажилласан.	70
10	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэлийг хангах, зохион байгуулах ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулах	Сумын ЗДТГ З.Солонго	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж, 1 хэсгийн хороог байгуулж, сонгуулийг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж 2021.06.09-ний өдөр санал авах ажиллагааг алдаа дутагдалгүй зохион байгуулсан.	100
11	Орон нутгийн онцлогийг харгалзан гамшгийн эрсдлийг тооцоолж шуурхай арга хэмжээ авч байх, шаардлагатай асуудлыг бие даан шийдвэрлэх	Сумын ЗДТГ З.Солонго	Өвөлжил, хаваржилт, байгалийн гэнэтийн аюулт үзэгдэл, Кодид-19 халдварт өвчнөөс урьчдлан сэргийлэх, эрсдлийг бууруулах, тэмцэх чиглэлээр сумын Онцгой комиссын хурлыг 16 удаа зохион байгуулж 19 шийдвэр гаргаж, гамшигтай тэмцэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.	100
12	Эрүүл мэндийн шинжилгээний төвд коронавирусыг илрүүлэх шинжилгээ хийх боловсон хүчнийг бэлтгэх, мэдээлийг цахимжуулах чиглэлээр ажиллах	ЭМТөв О.Энхмаа	Ковид-19 өвчлөлийн эмчилгээ үйлчилгээний тусламж, Коронавирусын эсрэг дархлаажуулалт сэдэвт цахим сургалтанд их эмч Н.Мөнхбаяр, Г.Бяцханбаяр нар 2021 оны 05 сард 5 хоног хамрагдсан. ЭМТ-ийн 3 их эмч, 5 сувилагч нийт 7 удаагийн дотоодын болон ЭМГ-аас зохион байгуулсан коронавирусыг илрүүлэх шинжилгээ хийх сургалтанд хамрагдсан. Нийт 8 ажилтан сорьц цуглуулах ажилд дайчлагдан ажиллаж байна.	70

13	Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгах төсөл, арга хэмжээний зураг, төсвийг бэлэн болгон аймгийн хэмжээнд нэгтгэн төсвийн цаглабарын дагуу төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байх	Сумын ЗДТГ Н.Батгэрэл	“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам ба аргачлалууд”-ын дагуу төсөлд тусгах 100 ортой шинэ цэцэрлэг бариулах санхүүжилтийг тусгуулах талаар үнэлгээнд оруулахаар холбогдох материалыг ХОХБТХ-ийн мэргэжилтэнд хүргүүлсэн.	50
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ				77,7

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

З.СОЛОНГО

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА

Д.БУДЖАВ